

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Азийн эмэгтэйчүүдийн төлөөх залбирал

Камбожид 2022–2023 онд бага ангийн охидын 9.5% нь сургууль завсардсан нь боловсролын боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна. Сургууль хол байх, гэр бүлийн ажилд дарагдах, соёлын дарамтаас болж охид сургуулиа орхих үед эрт гэрлэлт, ядуурлын дэвсгэрт мөчлөгт өртдөг.

TWR Камбожийн Women of Hope хөтөлбөр нь радио болон дижитал нэвтрүүлгүүдээр дамжуулан эмэгтэйчүүдэд өөрсдийгөө хамгаалах, аюулын шинж тэмдгийг таних, тусламж хүсэх аргуудыг зааж сургадаг. Тэд Есүсийг Аврагчаа гэж мэдэхийн хэрээр жинхэнэ үнэ цэнээ ойлгож, бэрхшээлийг зоригтойгоор даван туулах урам зориг авч, амьдралд нь урт хугацааны өөрчлөлт гарч эхэлдэг.

Залбирал, урам зориг, Есүсийн хайрын тусламжаар Камбожийн олон эмэгтэйчүүд ахин босох хүч тэвчээрийг олж байна.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

бололцоо хомс байх, нийгмийн шахалтад өртөх үедээ итгэлдээ бат зогсох хүч, Танд бүрэн итгэх итгэлээр дүүргээч. (2 Кор. 4:8–9)

4. Эзэн минь, Энэтхэгийн Карнатака мужийн хөдөө орон нутгийн эрчүүд архи болон онлайн мөрийтэй тоглоомд донтоод байна. Та эмэгтэйчүүдийг ажилтай болж, гэр бүлээ авч явахад нь туслаач. (Иса. 41:10)

5. Индонезийн удирдагчдад шударга шүүн тунгаах, зөвтөөр удирдан жолоодох агуу мэргэн ухаанаа хайрлаач, Бурхан минь. Хуулийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хамгаалагдаж байх болтугай. (Сур. 31:9)

6. Японд итгэгчид Христийг амьдралдаа даган дуурайснаар эргэн тойрныхондоо нөлөөлж, сайн мэдээ өргөн тархаж, олон хүн аврагдах болтугай. (Үйл. 2:40–47)

7. Өө Эзэн минь, БНСУ-ын дараагийн үеийн залуус Танд итгэх итгэлдээ бат зогсож, амьдралдаа Таныг биечлэн мэдрэх болтугай. (Еф. 5:15–16)

8. Бурхан минь, Монголын өрх толгойлсон эмэгтэйчүүдэд гэр бүлээ зөв удирдах мэргэн ухаан, хайр, амар амгаланг хайрлаач, Тэдний хүүхдүүд Таны замаар явж, Таны хамгаалал дор өсөж бойжих болтугай. (Сур. 22:6)

9. Непалын сүмүүдэд үүссэн хуваагдал нь итгэгчдийн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийн итгэлийг сулруулж байна. Эзэн минь, Таны хайр, үнэн тэднийг сэргээж, нэгтгэн эдгээх болтугай. (Ром. 15:5–6)

10. Пакистан дахь шинээр байгуулагдсан эмэгтэйчүүдийн бүлгийн гишүүд сүнслэг өсөлтөд хүрч, Таны Үгийг хамтдаа сонсож, нөхөрлөл, залбирлын амьдралаар бие биедээ дэмжлэг болох болтугай. (Кол. 1:9–10)

11. Папуа Шинэ Гвинейд гэр бүлийн болон овгийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдэд Таны зөвт байдал, аюулгүй байдал, эдгэлийг өгөөч. Нийгэм эмэгтэйчүүдийн үнэ цэнийг хүндэтгэж өөрчлөгдөх болтугай. (Дуу. 34:18)

12. Шри Ланкийн Махо бүсийн Христэд үнэнч итгэлтэй эмэгтэйчүүдийг нөхөр нь орхисон ч гэсэн Та тэднийг хүчтэй байлгаж, хангаж өгөөч. (2 Кор. 9:8)

1. 2025 оны аравдугаар сараас эхлэн Хазара хэлээр “Women of Hope” нэвтрүүлэг Афганистанд цацагдаж эхэлсэнд бид Танд талархаж байна, Эзэн минь. Энэ нэвтрүүлэг олон хүнд найдвар, эдгэрэл авчрах болтугай. (Иох. 17:3)

2. Камбожийн ард иргэд ажилгүйдэл өндөр, цалин хөлс багатай тул гэр бүлээ тэжээхэд хүндрэлтэй байна. Эзэн, тэднийг зөв зам руу чиглүүлж, хангаж өгөөч. (Дуу. 9:18)

3. Хятадын Христэд итгэгчид урам хугарах, нөөц

13. Тимор-Лестегийн хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдийн дунд төрөлтийн эрсдэл өндөр байна. Тэдэнд зориулсан эмнэлэг, эх барих тусламж, дэд бүтэц нэмэгдэх болтугай. (Дуу. 121:7–8)

14. Эзэн минь Вьетнамд хүн худалдаалах, мөлжлөгийн эрсдэлтэй эмэгтэйчүүдийг хамгаалж, суллаач. Урьдчилан сэргийлэх стратеги боловсруулахад олон нийтийг удирдаач. (Дуу. 20:1)

15. Камбожийн ард түмэн, удирдагчид хил хязгаарын маргаанаас үүдсэн зовлон дунд Танаас энх тайван, аюулгүй байдал, зөв шийдлийг эрэх болтугай. (Ном. 4:4)

16. Аав аа, Индонезийн ээжүүд ажил, гэр бүлээ зохицуулахад их ачаалалтай байдаг. Таны өмнө ирж амралт, хүчээ авах боломжийг тэдэнд олгооч. (Мат. 11:28)

17. Японы орон нутгийн сүмүүд гадаад иргэдтэй холбогдож, гадаад хэл дээр үйл ажиллагаа явуулдаг сүмүүдтэй хамтран сайн мэдээг түгээн Таны хаанчлалыг өргөжүүлэхэд нэгдэх болтугай. (Дэд. 10:17–19)

18. БНСУ-д амьдарч буй Хойд Солонгосоос дүрвэн ирсэн хүүхдүүд нийгэмд амжилттай дасаж, өөрийнхөө боломж, авьяасыг бүрэн хөгжүүлэхэд нь туслаач, Бурхан минь. (Лев. 19:34)

19. Монголын Христэд итгэгч эмэгтэйчүүд хайр, эв нэгдлээр бие биедээ түшиг тулгуур болж, Таны үйлчлэлд хүчтэй багана болон зүтгэх болтугай. (1 Кор. 12:12–13)

20. Непалын сайн мэдээг сонсоход эргэлзэж буй эмэгтэйчүүдийн зүрхийг зөөлрүүлж, Танд хандахад нь нүд, оюун санааг нь нээж өгөөч. (Еф. 1:18)

21. Папуа Шинэ Гвинейд охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс хамгаалах олон нийтийн сонор сэрэмжийг өргөжүүлээч (Дуу. 46:1)

22. Тимор-Лестегийн нийгэмд эмэгтэйчүүдийн дуу хоолойг дарах хортой дадал, тогтолцоонуудыг Таны үнэн чөлөөлж, эмэгтэйчүүд хүний ёсоор хүндлэгдэх болтугай. (Гал. 3:28)

23. Вьетнамын алслагдсан бүсийн Хмонг эмэгтэйчүүдийн дунд өндөр байдаг төрөлтийн эрсдэлийг бууруулахад аюулгүй төрөлт, чадварлаг тусламж, эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлээч. (Дуу. 32:7)

24. Индонезийн олон эмэгтэйчүүд албан бус салбарт хөдөлмөр эрхэлдэг. Эзэн минь, тэдний хөдөлмөр шударгаар үнэлэгдэж, үнэ цэнэ нь хүндлэгдэж байх болтугай. (1 Тим. 5:18)

25. Японд санхүүгийн бэрхшээл, сэтгэл санааны дарамт, утга учиргүй байдалтай тулгарч буй хүмүүст сайн мэдээ хүрч, Есүс дотор баяр хөөр, амар амгалан, найдвар олох болтугай. (Ром. 15:10–13)

26. Өнөөдөр БНСУ-д амьдарч буй 1 сая гаруй гадаад ажилчид шударгаар үнэлэгдэж, Таныг мэдэх боломжтой болох болтугай. (Лев. 19:13)

27. Монгол эмэгтэйчүүд Тангай харилцах харилцаагаараа амар амгалан, баяр хөөр, найдвар дүүрэн байж, цогц сайн сайхныг хүртэх болтугай. (Иох. 14:27)

28. Дэлхийн үзэлд ихээр автагдаж буй Непалын залуу бүсгүйчүүдийг өөртөө буцаан дуудан, Таны үнэн рүү эргүүлэн чиглүүлээч. (Ром. 12:2)

29. Папуа Шинэ Гвинейд гүтгэгдэж буй эмэгтэйчүүдийн амийг хамгаалж, айдас, дарлалын мөчлөгийг эвдэн, шударга ёс, энх тайвныг тогтоож өгөөч. (Дуу. 82:3)

30. Тимор-Лестед хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд хамгаалалт, эдгэрэл, найдвар олохуйц аюулгүй орон зай бий болох болтугай. Тэд энэрэнгүй нигүүлслийн тусламж, шударга ёсыг хүртэх болтугай. (Дуу. 9:9)

31. Вьетнамын эмэгтэйчүүдийн дунд улс төр, эдийн засаг, удирдлагын салбарт мэргэн ухаан, зориг, боломж жинхэнэ утгаараа хөгжих болтугай. (Сур. 31:25)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. 2026 оны төлөвлөгөө Эзэний хүслийн дагуу сайн төлөвлөгдөхийн төлөө
2. Залбиралын бүлгүүд илүү идэвхитэй байж, хүнээр болон сүнсээр өсөхийн төлөө.

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.